

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-173-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p>Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт <i>(Шинэчлэгдэж байгаа)</i> <i>/22хуудас NZ Part 173-ийн 2017 оны 03 сарын 10-ны А.3-д үндэслэсэн/</i></p>	<p align="center">НИСЛЭГИЙН ЖУРМЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА – ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ <i>/14 хуудас Хүчинтэй мөрдөгдөж байгаа 2002/</i></p>	<p align="center">Тайлбар</p>
<p>А Бүлэг - Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p>	
<p>173.1. Зорилго</p> <p>(a) Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:</p> <p>(1) хэрэглэлийн нислэгийн журам зохиох, засвар өөрчлөлт хийх байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны;</p> <p>(2) хэрэглэлийн нислэгийн журам зохиох техникийн стандартууд.</p> <p>(b) Энэ <u>Дүрэм нь хөдөлгүүр ажиллагаагүй болсон онцгой нөхцөлийн үед ашиглах үйл ажиллагааны үзүүлэлтийн хязгаарлалттай агаарын хөлгийн нислэгийн журам</u>, эсхүл нислэгийн замыг зохиоход хамаарахгүй.</p>	<p>173.1 Зорилго</p> <p>(a) Энэхүү дүрмийн зорилго нь, <u>Монгол Улсын нислэгийн мэдээллийн бүсэд ил харааны болон хэрэглэлийн нислэгийн дүрмийн дагуу нислэг үйлдэж буй агаарын хөлөгт ашиглах Нислэгийн журмыг зохиох, боловсруулах, нислэгээр баталгаажуулах байгууллагыг гэрчилгээжүүлэх, үйл ажиллагааных нь журмыг тогтооход оршино.</u></p> <p>(б) Энэхүү дүрэм нь хөдөлгүүр <u>татгалзах</u> үеийн Нислэгийн журам зохиоход үйлчлэхгүй.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>173.3. <u>Нэр томъёо болон товчлол</u></p> <p>Энэ Дүрэмтэй холбоотой нэр томъёо болон товчлол нь ИНД-ийн нэр томъёоны тайлбарт багтсан.</p>	<p>173.3 <u>Тодорхойлолт</u></p>	<p>-Нэр томъёоны тайлбар, тодорхойлолтууд ИНД-1-д орсон.</p>
<p>173.5. <u>Гэрчилгээний шаардлага</u></p> <p>Аливаа этгээд нь энэ Дүрмийн дагуу олгосон хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын (цаашид “ХНЖҮБ” гэх) гэрчилгээний эрх хязгаарлалтад заагаагүй хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээг Монгол Улсын FIR-д үзүүлэхгүй байх үүрэгтэй:</p>	<p>173.5 <u>Гэрчилгээжүүлэх шаардлага</u></p> <p>(a) Энэ дүрмийн дагуу Нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшээгүй хуулийн этгээд нь Монгол Улсын нислэгийн мэдээллийн бүсэд нислэгийн журмын үйлчилгээ эрхлэхийг хориглоно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>173.7. <u>Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах</u></p> <p>ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА 24173/01 маягтыг бөглөж, дараах баримтын хамт <u>Даргад</u> хүргүүлэх үүрэгтэй:</p> <p>(1) 173.71-д шаардсан <u>хүсэлт гаргагчийн Ерөнхий</u> заавар;</p>	<p>173.7 <u>Өргөдөл гаргах</u></p> <p>(a) Нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ хүсэгч нь ИНЕГ-0173/01 маягтын дагуу өргөдөл гаргаж, энэ дүрмийн 173.73-т заасан Үйл</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>(2) хэрэв хамааралтай бол, зохих төлбөрийн баримт.</p>	<p>ажиллагааны зааврын хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ. (б) ИНЕГ-ын дарга нь, өргөдөл гаргагч дараах шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ: 1/ энэ дүрмийн Б. Бүлгийн шаардлага; 2/ энэ дүрмийн 173.51(а)-ын 1/, 2/, 3/-т заасан албан тушаалтан болон ажилтан тус бүрийн ажлын байранд тавигдах шаардлага; 3/ гэрчилгээ олгосноор нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа нь нисэхийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй тохиолдолд.</p>	
<p>173.9. Гэрчилгээ олгох Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагчид ХНЖҮБ-ын гэрчилгээ олгоно: (1) хүсэлт гаргагч В Бүлгийн шаардлага хангасан байх; (2) хүсэлт гаргагч болон 173.51(а)-д шаардсан удирдах ажилтнууд нь тохирох зөв хүн байх; (3) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.</p>	<p>173.9 Гэрчилгээ олгох (а) ИНЕГ-ын дарга шаардлага хангасан өргөдөл гаргагчид Нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ олгоно: (б) Нислэгийн журмын үйлчилгээний байгууллагад гэрчилгээ олгосон өдрөөс Нислэгийн журам зохиох, боловсруулах, нислэгээр батлах болон гэрчилгээжүүлэх эрх үүснэ. (в) Гэрчилгээнд, журам зохиох, боловсруулах, нислэгээр батлах болон гэрчилгээжүүлэх хэрэглэлийн нислэгийн дүрмийн төрлүүдийг заасан байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>173.11. Гэрчилгээ эзэмшигчийн эрх ХНЖҮБ-ын гэрчилгээ нь: (1) гэрчилгээ эзэмшигчид дараах эрхийг олгоно: (i) хэрэглэлийн нислэгийн журам зохиох, нислэгээр баталгаажуулах, гэрчилгээжүүлэх болон засвар өөрчлөлт хийх; (ii) ИНД-95-ын шаардлагыг харгалзан тухайн эзэмшигч гэрчилгээжүүлсэн ба www.mcaa.gov.mn цахим хуудсаар мэдээлсэн хэвлэн нийтлэх болон агаарын хөлгийн үйл ажиллагаанд ашиглахад бэлэн, хэрэглэлийн нислэгийн журамтай холбоотой нисэхийн өгөгдлийг багтаасан нисэхийн мэдээллийг гаргах; (2) тухайн гэрчилгээ эзэмшигчийн зохиох, нислэгээр баталгаажуулах, гэрчилгээжүүлэх болон засвар өөрчлөлт хийх эрх олгогдсон хэрэглэлийн нислэгийн журмын төрлийг заана.</p>		<p>-Орхигдуулсан заалт нэмж оруулсан</p>
<p>173.13. Гэрчилгээний хугацаа (а) ХНЖҮБ-ын гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно. (б) ХНЖҮБ-ын гэрчилгээ нь түүний хугацаа дууссан, түдгэлзүүлсэн,</p>	<p>173.11 Гэрчилгээний хүчинтэй хугацаа (а) Гэрчилгээг 3 жил хүртэлх хугацаагаар олгоно. (б) Гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан, гэрчилгээний үйлчлэлийг тодорхой хугацаагаар</p>	<p>-Орчуулга, найруулга зассан - “3 жил” гэснийг “5 жил” гэж өөрчлөгдсөн</p>

<p>эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчинтэй хэвээр байна.</p>	<p>түдгэлзүүлсэн буюу хүчингүй болгосноос бусад тохиолдолд гэрчилгээ хүчин төгөлдөр байна.</p> <p>(в) Гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан, эсхүл гэрчилгээг хүчингүй болгосон тохиолдолд эзэмшигч нь гэрчилгээгээ ИНЕГ-ын даргад ирүүлнэ.</p> <p>(г) Гэрчилгээг түдгэлзүүлсэн тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь зөрчил, дутагдлаа арилгасны үндсэн дээр гэрчилгээг сэргээх тухай хүсэлтээ ИНЕГ-ын даргад гаргана.</p>	
<p>173.15. Гэрчилгээ сунгах</p> <p>(а) ХНЖҮБ-ын гэрчилгээ сунгуулах хүсэлтийг САА 24173/01 маягтын дагуу гаргах ёстой.</p> <p>(б) Хүсэлтийг тухайн гэрчилгээнд заасан сунгах хугацаанаас өмнө, эсхүл хэрэв сунгах хугацааг заагаагүй бол тухайн гэрчилгээний хугацаа дуусахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө Даргад хүргүүлэх үүрэгтэй.</p>	<p>173.13 Гэрчилгээний хугацааг сунгах</p> <p>(а) Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацааг сунгуулах өргөдлийг ИНЕГ-0173/01 маягтын дагуу гаргаж, гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө ИНЕГ-ын даргад ирүүлнэ.</p> <p>(б) Гэрчилгээ эзэмшигч Монгол Улсын нислэгийн мэдээллийн бүсэд ислэгийн журмын үйлчилгээ эрхлэх, нислэгийн журам зохиох, боловсруулах журам, нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд хугацааг сунгахгүй.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага</p>	<p>Б.БҮЛЭГ. ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА</p>	
<p>173.51. Ажилтанд тавих шаардлага</p> <p>(а) ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтныг үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй:</p> <p>(1) Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон дараах үүрэгтэй удирдах ажилтан:</p> <p>(i) тухайн байгууллагын хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээг санхүүжүүлэх ба энэ Дүрэмд заасан шаардлага болон стандартын дагуу гүйцэтгэж чадахаа хүсэлт гаргагчийн байгууллагын хүрээнд бататгах эрхтэй;</p> <p>(ii) тухайн байгууллага нь энэ Дүрэмд заасан шаардлага болон стандартыг хангаж байгааг бататгах;</p> <p>(2) Гүйцэтгэх захирлын өмнө дараах үйл ажиллагааг хариуцсан удирдах ажилтан, эсхүл ажилтнууд:</p> <p>(i) хүсэлт гаргагчийн байгууллага нь Ерөнхий заавраа дагаж мөрдөж байгааг бататгах;</p> <p>(ii) ИНД-95-ын дагуу Монгол Улсын ANR-д оруулах зорилгоор тухайн хүсэлт гаргагч байгууллагын гаргасан хэвлэн нийтлэх болон үйл ажиллагаанд ашиглахад бэлэн болгосон хэрэглэлийн нислэгийн журам бүрийг гэрчилгээжүүлэх;</p>	<p>173.51 Боловсон хүчинд тавигдах шаардлага</p> <p>(а) Нислэгийн журмын үйлчилгээний байгууллага нь дараах ажилтнуудтай байна:</p> <p>1/ байгууллагын үйл ажиллагаа энэхүү дүрмийн шаардлагын дагуу явагдаж, санхүүжиж байгааг бататгах эрх бүхий удирдах албан тушаалтан;</p> <p>2/ байгууллага нь үйл ажиллагааны зааврынхаа дагуу ажиллаж байгааг бататгах хариуцлага хүлээсэн гүйцэтгэх албан тушаалтан буюу ажилтан;</p> <p>3/ Нислэгийн журмыг төлөвлөх, зохиох, боловсруулах, батлах хангалттай тооны ажилтантай байх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>- Amend.2-оор нэмэгдсэн</p>

<p><u>(iii) 173.69-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо:</u> <u>(3) хүсэлт гаргагчийн байгууллагаас нийлүүлэх хэрэглэлийн нислэгийн журмыг төлөвлөх, зохиох, бататгах болон засвар өөрчлөлт хийх хангалттай тооны ажилтан.</u></p> <p>(b) ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтны ур чадварт <u>сүүрх үнэлгээ хийх</u>, <u>сургах</u> болон ур чадварыг хадгалах журмыг тогтоосон байх үүрэгтэй:</p> <p>(1) хэрэглэлийн нислэгийн журмыг төлөвлөх, зохиох, зохиолтыг <u>бататгах</u> болон <u>засвар өөрчлөлт хийх</u> ажилтнууд; (2) хэрэглэлийн нислэгийн журмыг гэрчилгээжүүлэх эрх олгогдсон <u>удирдах</u> ажилтнууд.</p> <p>(c) Хэрэглэлийн нислэгийн журмын гэрчилгээжүүлэлт хариуцсан <u>удирдах</u> ажилтан, эсхүл ажилтнуудад тухайн журмыг гэрчилгээжүүлэх эрхийг 173.57-гийн дагуу олгосон байх ёстой.</p> <p>(d) Энэ зүйлийн (a)(2)-т заасан <u>удирдах</u> ажилтнуудын мэргэшил болон туршлагыг Хавсралт А-д заасан.</p>	<p>(б) Нислэгийн журмын үйлчилгээний байгууллага нь дараах ажлын байрны хувьд ажилтнуудын ур чадварыг <u>үнэлэх, дадлагажуулах</u>, хадгалах журмыг боловсруулна: 1/ Нислэгийн журмыг төлөвлөх, зохиох, <u>боловсруулах, батлах</u> ажилтан; 2/ Нислэгийн журмыг гэрчилгээжүүлэх <u>эрх бүхий</u> ажилтан.</p> <p>(в) Нислэгийн журмын гэрчилгээжүүлэлт хариуцсан ажилтанд энэ дүрмийн 173.61-ийн дагуу эрх олгогдсон байна.</p> <p>Тайлбар: Гэрчилгээжүүлэлт хариуцсан ажилтанд тавигдах мэргэшил болон ур чадварын шаардлагыг Хавсралт А-д заасан.</p>	
<p>173.53. <u>Ашиглах төхөөрөмж болон баримт бичигт тавих шаардлага</u></p> <p>(a) ХНЖҮБ-ын <u>гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> дараах үүрэгтэй:</p> <p>(1) <u>хүсэлт гаргагчийн Ерөнхий</u> зааварт заасан хэрэглэлийн нислэгийн журмын төрлийг зохиох, зохиолтыг бататгах, гэрчилгээжүүлэх, нислэгээр <u>баталгаажуулах болон засвар өөрчлөлт хийхэд</u> тохиромжтой төхөөрөмжийг ашиглахад бэлэн байлгах; (2) тухайн <u>хүсэлт гаргагчийн байгууллагын гэрчилгээжүүлэх, засвар өөрчлөлт хийх хэрэглэлийн</u> нислэгийн журмыг зохиох, зохиолтыг бататгах, нислэгээр баталгаажуулах <u>болон засвар өөрчлөлт хийхэд шаардлагатай нисэхийн өгөгдлийг багтаасан гэхдээ үүгээр</u>, газрын хаялбарын өгөгдөл болон саадын өгөгдлөөр <u>хязгаарлагдахгүй бусад холбогдох, хүчинтэй өгөгдлийг ашиглах боломжтой байх</u>; (3) <u>хүсэлт гаргагчийн Ерөнхий</u> зааварт заасан хэрэглэлийн нислэгийн журмын төрлийг зохиох, <u>зохиолтыг бататгах</u>, гэрчилгээжүүлэх, <u>нислэгээр баталгаажуулах болон засвар өөрчлөлт хийхэд хамаарах</u> техникийн стандарт, <u>зөвлөмж зааварчилгаа</u> болон бусад шаардлагатай байж болох баримт</p>	<p>173.53 <u>Тоног төхөөрөмжийн нөөцөд тавигдах шаардлага</u></p> <p>(a) <u>Нислэгийн журмын үйлчилгээний байгууллага нь</u> дараах тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан байна. Үүнд: 1/ <u>Үйл ажиллагааны</u> зааварт тусгагдсан Нислэгийн журмын төрлүүдийг зохиох, боловсруулах, нислэгээр батлахад шаардлагатай тоног төхөөрөмж; 2/ Нислэгийн журмыг зохиох, батлах, гэрчилгээжүүлэхэд шаардлагатай нислэгийн өгөгдөл, газрын хаялбарын өгөгдөл болон <u>саадын өгөгдлүүд</u>; 3/ <u>Үйл ажиллагааны</u> зааварт тусгагдсан Нислэгийн журмын төрлийг зохиох, гэрчилгээжүүлэх, нислэгээр батлах болон шаардлагатай техникийн стандарт, <u>зөвлөмж, заавруудаас</u> бүрдсэн холбогдох баримт бичгийн хувь;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Ерөнхий заавар нь үйл ажиллагааны заавраас тусдаа</p> <p>- Amend.1-ээр нэмэгдсэн</p>

<p>бичгээс бүрдсэн холбогдох баримт бичгийн хувийг эзэмшдэг байх, эсхүл ашиглахад бэлэн байлгах.</p> <p>(b) ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:</p> <p>(1) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан тухайн хэрэглэлийн нислэгийн журмын төрөлд шаардлагатай энэ зүйлийн (a)(2)-т заасан өгөгдлийг ажилтнууд ашиглах боломжтой байлгах;</p> <p>(2) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан хэрэглэлийн нислэгийн журам зохиох, зохиолтыг бататгах, нислэгээр баталгаажуулах болон засвар өөрчлөлт хийхэд зориулсан энэ зүйлийн (a)(2)-т заасан өгөгдөл нь хүчинтэй эргэн тогтоох боломжтой байх ба шалгаж болохуйц нарийвчлалын шаардлагатай түвшнийг хангасан байх.</p> <p>(c) ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах зорилгоор энэ зүйлийн (a)(3)-т шаардсан бүх баримт бичгийг хянах журмыг тогтоосон байх үүрэгтэй:</p> <p>(1) баримт бичгийг боловсруулж гаргах болон ашиглахын өмнө холбогдох этгээд хянаж, зөвшөөрдөг байх;</p> <p>(2) хэрэв ажилтан авч ашиглах шаардлагатай бол холбогдох баримт бичгийн хүчинтэй хувийг шаардлагатай байрлал бүрд бэлэн байлгах;</p> <p>(3) хүчингүй болсон баримт бичгийг боловсруулж гаргасан болон ашиглаж байгаа цэг бүрээс нэн даруй хураан авдаг байх;</p> <p>(4) баримт бичигт орсон нэмэлт өөрчлөлтийг боловсруулж гаргах болон ашиглахын өмнө холбогдох этгээд хянаж, зөвшөөрдөг байх;</p> <p>(5) өөрчлөгдөж хүчингүй болсон материалыг ашиглахаас сэргийлж баримт бичгийн хуудас бүрийн хүчинтэй хувилбарыг таньж тогтоож болдог байх.</p>	<p>4/ нарийвчилсан тооцоо хийхэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлж тусгайлан тоноглосон, гадна орчноос тусгаарлагдсан ажлын байр.</p> <p>(б) Нислэгийн журмын үйлчилгээний байгууллага нь, энэ зүйлийн (a) 2/-т заасан өгөгдлийг ашиглах журмыг боловсруулсан байна.</p> <p>Тайлбар. Энэ зүйлийн (a) 2/-т заасан өгөгдөл нь хүчин төгөлдөр, мөрдөх боломжтой бөгөөд Үйл ажиллагааны зааварт заасан хэрэглэлийн нислэгийн журмыг зохиох, түүнийг нислэгээр баталгаажуулахад шаардлагатай нарийвчлалын түвшинг агуулсан байна.</p> <p>(в) Нислэгийн журмын үйлчилгээний байгууллага нь дараах зүйлүүдийг бататгах зорилгоор, энэ зүйлийн (a) 3/-т заасан баримт бичгүүдийн хяналтын журмыг боловсруулсан байна. Үүнд:</p> <p>1/ баримт бичгийг олгох буюу ашиглаж эхлэхээс өмнө зохих ажилтан шинэчилж, баталгаажуулах талаар;</p> <p>2/ холбогдох баримт бичгийн хүчин төгөлдөр хувийг ажлын байранд байрлуулах талаар;</p> <p>3/ хүчингүй болсон баримт бичгийг тухай бүр ашиглалтаас гаргах талаар;</p> <p>4/ баримт бичигт оруулах нэмэлт, өөрчлөлтийг хянах талаар;</p> <p>5/ баримт бичгийн бүрэлдэхүүн хэсэг бүрийн хүчин төгөлдөр хувийг хуучин хувиас нь ялгаж таних боломжтой байх талаар.</p>	
<p>173.55. Хэрэглэлийн нислэгийн журам зохиох</p> <p>(a) ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн хүсэлт гаргагчийн гэрчилгээний эрхийн хүрээнд 173.59-ийн дагуу гэрчилгээжүүлэх хэрэглэлийн нислэгийн журам бүрийг дараах шаардлагыг хангасан болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:</p>	<p>173.55 Нислэгийн журам</p> <p>(a) Өргөдөл гаргагч нь дараах нөхцөлүүдийг хангасан гэдгийг бататгах Нислэгийн журам боловсруулах болон хянаж батлах журамтай байна:</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

(1) тухайн журмыг, D Бүлэгт заасан холбогдох шаардлага болон стандартыг хангасан болохыг бататгасан аргачлалыг ашиглан зохиодог, эсхүл нэмэлт, өөрчлөлт хийдэг байх;

(2) гэрчилгээжүүлэхийн өмнө тухайн журам зохиолтыг шууд хариуцаж хийсэн этгээдээс хамааралгүй мэргэшсэн ажилтан хараат бусаар бататгадаг байх;

(3) энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, дараах шаардлагыг бататгах зорилгоор энэ зүйлийн (c)-д шаардсан журмын дагуу нислэгээр баталгаажуулдаг байх:

(i) хэрэглэлийн нислэгийн журам нь тухайн журмыг зориулж гаргасан агаарын хөлгийн категорийн хувьд, аюулгүй ажиллах практик дадал болон нисгэгчийн ажлын ачааллын хүрээнд уг журмыг ашиглан маневрыг шат дараатайгаар гүйцэтгэх боломжийг агаарын хөлөгтолгодог байх;

(ii) хэрэглэлийн нислэгийн журам нь, тухайн журмыг ашиглаж байгаа агаарын хөлөг саадаас чөлөөтэй байгааг бататгах зорилгоор ICAO эсхүл агаарын хөлгийн үйл ажиллагаанд зориулсан бусад стандартын дагуу азимут, зайн мэдээлэл болон нарийвчлалтай ойртолтын босоо чиглүүлэлтийн мэдээллээр хангадаг байх;

(iii) хэрэглэлийн нислэгийн журам нь аливаа радио давтамжийн нөлөөнд автдаггүй байх;

(iv) ил харааны чиглүүлэлтийн систем болон ХБЗ-ны ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ нь тухайн хэрэглэлийн нислэгийн журамд тохирдог байх ба гэрэлтүүлэг, лазерын гэрлээр тэнгэрт тусгах үзүүлбэр, эсхүл бусад ил хараа сарниулах хэрэгслээр төөрөгдүүлэхээргүй байх.

(b) Хэрэв хүчинтэй саадын өгөгдөл нь тухайн хэрэглэлийн нислэгийн журмын зохиолтын шаардлагыг хангасан болохыг харуулж байгаа бол, дараах хэрэглэлийн нислэгийн журмыг нислэгээр баталгаажуулахыг шаардахгүй:

(1) дараахаас бусад тохиолдолд, нислэгийн замын эсхүл хэрэглэлээр нисэн ирэх журам:

(i) тухайн журмын шаардлагыг дэмждэг навигацийн системийн бүрхэлтэд эргэлзэх шалтгаан байгаа; эсхүл

(ii) тухайн журам нь түүнийг зориулан зохиосон ангиллын агаарын хөлгийн нисэх чадвар болон техникийн үзүүлэлтийг хязгаарладаг байх;

(2) тухайн журам нь түүнийг зориулан зохиосон ангиллын агаарын хөлгийн нисэх чадвар болон техникийн үзүүлэлтийг хязгаарладаг байхаас бусад тохиолдолд хэрэглэлээр нисэн

1/ энэ дүрмийн Г.Бүлэгт заасан холбогдох шалгуур болон шаардлагыг хангасан аргыг ашиглан зохиогдсон гэдгийг;

2/ гэрчилгээжүүлэлтээс өмнө, зохиох үйл ажиллагаанд оролцоогүй мэргэшсэн ажилтан шалгаж баталсан гэдгийг.

гарах журам;

(3) өмнө нь нислэгээр баталгаажуулсан хэрэглэлээр ойртолт үйлдэх журмын нэмэлт өөрчлөлт, хэрэв:

(i) зохиолтын өөрчлөлтийг журам зохиох үйл явцын үед бататгаж чадаж байгаа бол;

(ii) санал болгосон нэмэлт өөрчлөлтөд аюулгүй байдлын үнэлгээ хийгдсэн ба тухайн нэмэлт өөрчлөлтөөр тухайн журмын аюулгүй байдалд нэмэлт эрсдэл учруулахгүй болохыг бататгасан бол.

(c) ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (a)(3)-т шаардсан хэрэглэлийн нислэгийн журмыг нислэгээр баталгаажуулах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

(d) Энэ зүйлийн (c)-д шаардсан нислэгээр баталгаажуулах журам нь дараах төхөөрөмж ашиглах шаардлагыг багтаасан байх ёстой:

(1) оновчтой ба тухайн хийж байгаа баталгаажуулалтад шаардлагатай холбогдох стандартад тохирсныг эргэн тогтоох боломжтой нарийвчлалтай байх;

(2) програм хангамж, системийн програм болон хөндлөнгийн салхины тодорхойгүй байдлыг багтаасан гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй хэмжлийн тодорхойгүй байдлыг тогтоосон байх;

(3) баталгаажуулалт хийх агаарын хөлгийн бодит нислэгийн замыг бичдэг байх.

(4) тухайн систем нь хэрэглэлийн нислэгийн журмын үнэн зөв байдлыг бататгах чадамжтай болохыг тогтоох зорилгоор ашиглахаар гаргахын өмнө болон үйлдвэрлэгчийн зөвлөсөн тохируулга хийх үечлэлээс хэтрэхгүй үечлэлээр шалгадаг байх.

(5) нислэгээр баталгаажуулах системийн журам болон шалгуурын дагуу тухайн ашиглаж байгаа системийг мэддэг эрх бүхий ажилтан ажиллуулдаг байх.

(e) ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь хэрэглэлийн нислэгийн журамд энэ зүйлийн (b)-гийн шаардлагыг хэрхэн хангасныг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

(f) ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь хэрэглэлийн нислэгийн журам зохиох, засвар өөрчлөлт хийх болон өгөгдлийг дамжуулах ажиллагааны үед дараах шаардлагыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

(1) холбогдох нисэхийн өгөгдөл болон нисэхийн мэдээлэл нь RTCA Inc. Doc. RTCA/DO-201A Нисэхийн Мэдээллийн Стандарт баримт бичигт заасан стандартыг хангасан байх;

<p><u>(2) нисэхийн өгөгдлийг өөрчлөх, эсхүл боловсруулах ажиллагаа нь RTCA Inc. Doc RTCA/DO-200A Нисэхийн Өгөгдөл Боловсруулах Стандарт баримт бичигт заасан стандартыг хангасан байх;</u></p> <p><u>(3) гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын хүрээнд, эсхүл гадны байгууллагаас, эсхүл байгууллагад нисэхийн мэдээлэл дамжуулах ажиллагаа нь Нисэхийн Мэдээлэл Дамжуулах Загварт (AIXM-5) заасан стандартыг хангасан байх.</u></p> <p><u>(g) ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (f)-д заасан стандарттай дүйцэх өөр орлох стандарт ашиглаж болно.</u></p>		
<p>173.57. Хэрэглэлийн нислэгийн журмыг гэрчилгээжүүлэх ажилтанд эрх олгох</p> <p>(a) Энэ зүйлийн (b),(c) болон (d)-г харгалзан, <u>ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, хэрэглэлийн нислэгийн журмыг D Бүлэгт заасан холбогдох стандарт болон шаардлагын дагуу зохиосон ба эдгээр шаардлагыг хангасан болохыг гэрчилгээжүүлэх удирдах ажилтан, эсхүл ажилтнуудад эрх олгох журмыг тогтоосон байх үүрэгтэй.</u></p> <p>(b) Этгээд нь Хавсралт А.1-д заасан холбогдох сургалт болон дадлагын шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд тухайн этгээдэд эрх олгохгүй.</p> <p>(c) Ажилтанд олгосон эрхийг бичгээр үйлдсэн байх ёстой ба тухайн ажилтанд гэрчилгээжүүлэх эрх олгосон хэрэглэлийн нислэгийн журмын төрлийг заасан байх ёстой.</p> <p>(d) Тухайн эрхэд заасан хэрэглэлийн нислэгийн журмын төрөл нь хэрэглэлийн нислэгийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээнд заасан хэрэглэлийн нислэгийн журмын төрөлд нийцсэн байх ёстой.</p>	<p>173.57 Нислэгийн журмыг батлах</p> <p>(a) Энэ дүрмийн 173.59-д заасны дагуу гэрчилгээжих Нислэгийн журам бүр нь дараах нөхцөлүүдийг хангасан гэдгийг бататгасан байна:</p> <ol style="list-style-type: none"> 1/ энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд, нислэгийн журмыг зохиох, боловсруулах, батлах болон энэ зүйлийн (в)-д заасан журмын дагуу нислэгээр баталсан байх; 2/ хэрэглэлийн нислэгийн журмыг ашиглахад тухайн ангиллын агаарын хөлөг хэвийн аюулгүй ажиллагааны нөхцөл болон нисгэгчийн ажлын ачааллын хүрээнд маневр хийх боломжтой байх; 3/ хэрэглэлийн нислэгийн журам нь тухайн журмаар нисч буй агаарын хөлөг саадаас чөлөөлөгдсөн байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд ICAO-ийн болон бусад, агаарын хөлгийн үйл ажиллагааны стандартын дагуу нарийвчлалтай ойртолтын зүг чиг, зайн мэдээлэл болон өндрийн мэдээллийг агуулсан байх; 4/ хөөрч буух зурвасны гэрэл суултын систем болон таних тэмдэг нь тухайн хэрэглэлийн нислэгийн журамд ашиглахад тохиромжтой байх ба зурвасны гэрэл, өндөрт байрласан лазер самбар болон бусад анхаарал сарниулж болзошгүй зүйлстэй андуурагдахгүй байх; 5/ Нислэгийн журам нь аливаа радио давтамжийн тасалдлын нөлөөнд автахгүй байх. <p>(б) Хүчин төгөлдөр саадын өгөгдөл нь Нислэгийн журам</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

	<p>зохиох шаардлагыг хангаж байгаа тохиолдолд дараах Нислэгийн журмыг нислэгээр батлах шаардлагагүй:</p> <ol style="list-style-type: none"> 1/ ил хараагаар ойртолт үйлдэх журам; 2/ дор дурдсанаас бусад үед маршрутын буюу хэрэглэлээр нисэн ирэх журам: <ol style="list-style-type: none"> 2.1 журмыг зохиоход ашиглагдах навигацийн тоног төхөөрөмжийн сигналын бүрхэлтэд эргэлзээ байгаа тохиолдолд; эсхүл 2.2 журмыг зохиосон ангиллын агаарын хөлгийн нисэх чадвар болон гүйцэтгэлийн үзүүлэлтийг хязгаарласан тохиолдолд. 3/ зохиосон ангиллын агаарын хөлгийн нисэх чадвар болон гүйцэтгэлийн үзүүлэлтийг хязгаарлаагүй тохиолдолд хэрэглэлээр нисэн гарах журам. <p>(в) Өргөдөл гаргагч нь хэрэглэлийн нислэгийн журмыг нислэгээр батлах журамтай байна.</p> <p>(г) Хэрэглэлийн нислэгийн журмыг нислэгээр батлахад дараах шаардлагуудыг хангасан тоног төхөөрөмжийг ашиглана:</p> <ol style="list-style-type: none"> 1/ нислэгээр батлахад хангалттай бөгөөд зохих стандартад хамаарах нарийвчлалтай; 2/ программ хангамж, ROM программ болон хөндлөнгийн салхины хэмжилтийн алдаа, зэрэг хэмжилтийн нарийвчлалын алдааг урьдчилан тогтоодог; 3/ нислэгээр батлахад ашиглаж буй агаарын хөлгийн бодит нислэгийн замыг бүртгэдэг; 4/ хэрэглэлийн нислэгийн журмын бүтэн байдлыг шалгаж батлах боломжийг хангах болон үйлдвэрлэгчээс зөвлөсөн хэмжилтийн нарийвчлалыг шалгах үечлэлийн дагуу тогтмол тохиргоо хийгддэг; 5/ нислэгээр батлах системийн заавар болон шалгуурын дагуу ашиглах чадвартай мэргэшсэн ажилтан уг системийг ажиллуулдаг байх. <p>(д) Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (г)-д заасан тоног төхөөрөмж, ажилтангүй тохиолдолд хэрэглэлийн нислэгийн журмыг нислэгээр батлах ажлыг холбогдох шаардлагыг хангасан байгууллагаар гүйцэтгүүлж болно.</p>	
173.59.	<u>Хэрэглэлийн</u> нислэгийн журмыг гэрчилгээжүүлэх	173.59 Нислэгийн журмын гэрчилгээжүүлэлт
		-Орчуулга, найруулга

<p>(a) Энэ зүйлийн (b) болон (c)-г харгалзан, ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын зохиох үйл ажиллагаанд ашиглахад бэлэн болгох ба Монгол Улсын AIP-д хэвлэн нийтлэхээр төлөвлөж байгаа хэрэглэлийн нислэгийн журмыг гэрчилгээжүүлэх журмыг тогтоосон байх үүрэгтэй.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан журам нь дараах мэдээллийг багтаасан байх ёстой:</p> <p>(1) хэрэглэлийн нислэгийн журам нь энэ Дүрэмд заасан холбогдох шаардлага болон стандартад нийцэж байгааг бататгах зорилгоор тодорхой хэрэглэлийн нислэгийн журмын төрлийг гэрчилгээжүүлэх эрх олгогдсон удирдах ажилтны гүйцэтгэх шалгалтын дэлгэрэнгүй;</p> <p>(2) Монгол Улсын ANR-д хэрэглэлийн нислэгийн журмыг оруулах зорилгоор 173.61(с)-д заасан мэдээллээр Даргыг хангах аргачлал.</p> <p>(c) ИНД-173.57-гийн дагуу хэрэглэлийн нислэгийн журмыг гэрчилгээжүүлэх эрх олгогдсон этгээдэд өөрийн зохиосон хэрэглэлийн нислэгийн журмыг гэрчилгээжүүлэхийг зөвшөөрөхгүй.</p>	<p>(a) Нислэгийн журмын үйлчилгээний байгууллага нь зохиох Нислэгийн журам бүрийг гэрчилгээжүүлэх журамтай байх бөгөөд тэдгээрийг үйл ажиллагаандаа ашиглах болон нисэхийн мэдээллийн эмхтгэл (цаашид НМЭ гэх)-д хэвлэхэд бэлэн болгох үүрэгтэй.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д заасан журам нь дараах зүйлийг агуулна:</p> <p>1/ Нислэгийн журам нь энэ дүрмийн шаардлагад нийцэж буйг бататгахын тулд нислэгийн журмыг гэрчилгээжүүлэх эрх олгогдсон ажилтныг шалгах арга хэлбэр;</p> <p>2/ Нислэгийн журмыг агаарын навигацийн бүртгэлд оруулахдаа 173.63(в)-д заасны дагуу шаардлагатай мэдээллээр ИНЕГ-ын даргыг хангах арга хэлбэр.</p> <p>(в) Энэ дүрмийн 173.61-д заасны дагуу Нислэгийн журам гэрчилгээжүүлэх эрх бүхий ажилтан нь өөрийн зохиосон нислэгийн журмыг гэрчилгээжүүлэхгүй.</p>	<p>зассан</p>
<p>173.61. Хэрэглэлийн нислэгийн журмыг түгээх</p> <p>(a) ИНД-95.51-ийн дагуу, ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:</p> <p>(1) энэ зүйлийн (c)-д шаардсан мэдээллээр Даргыг хангасан байх;</p> <p>(2) Дарга ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмшигчид тухайн хэрэглэлийн нислэгийн журмыг Монгол Улсын ANR-д оруулсан болохыг мэдээлсэн ба ИНД-95.55-ын дагуу хэрэглэлийн нислэгийн журмын үйл ажиллагаанд ашиглах хугацааг www.mcaa.gov.mn цахим хуудсаар мэдээлснээс бусад тохиолдолд тухайн журмыг хэвлэн нийтэлдэггүй, эсхүл үйл ажиллагаанд ашиглахад зориулан бэлэн болгодоггүй байх.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан журам нь дараах үйл ажиллагааг багтаасан байх ёстой:</p> <p>(1) Монгол Улсын AIP-д хэрэглэлийн нислэгийн журмыг хэвлэн нийтлэх, нисэхийн мэдээллийн үйлчилгээгээр хангадаг байгууллагатай зохицуулалт хийх аргачлалын дэлгэрэнгүй;</p> <p>(2) энэ зүйлийн (a)-ийн дагуу хэвлэн нийтэлсэн хэрэглэлийн</p>	<p>173.65 Нислэгийн журмын боловсруулалт</p> <p>(a) Нислэгийн журмын үйлчилгээний байгууллага нь ашиглагдаж буй Нислэгийн журам бүрт 173.63 (в) 5/-д заасны дагуу олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд, дүрмийн шаардлагад нийцүүлэн байнгын боловсруулалт хийх журамтай байна.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д заасан журам нь дараах мэдээллийг багтаасан байна:</p> <p>1/ Нислэгийн журам нь энэ дүрмийн шалгуур болон шаардлагад нийцэж байгааг тодорхой хугацааны үечлэлээр бататгах;</p> <p>2/ 173.53 (a) 2/-т заасан аливаа өгөгдөлд Нислэгийн журмын бүтцэд нөлөөлж болзошгүй боловсруулалт хийсэн тохиолдолд.</p> <p>(в) Энэ зүйлийн (a)-д заасан журамд, Нислэгийн журмын боловсруулалтад дүн шинжилгээ хийх, хоорондын үечлэлийг тогтоох буюу өөрчлөх үндэслэл болон шалгуурыг багтааж баримтжуулсан байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Орхигдуулсан заалтыг</p>

<p><u>нисклгийн журмын анхны хэвлэлт, эсхүл түүнд орох аливаа өөрчлөлт нь Монгол Улсын АИР-д үнэн зөв хэвлэн нийтэлсэн болохыг шалгах аргачлалын дэлгэрэнгүй мэдээлэл.</u></p> <p>(с) Дарга хэрэглэлийн нисклгийн журмыг Монгол Улсын ANR-д оруулах бүрдээ дараах мэдээллийг шаардана:</p> <p>(1) тухайн хэрэглэлийн нисклгийн журмыг тусгайлан таньж тодорхойлох, Даргын хүлээн зөвшөөрөхүйц нэр, эсхүл бусад таних нэр томьёо;</p> <p>(2) тухайн хэрэглэлийн нисклгийн журмыг тодорхойлох болон дүрслэх, Даргын хүлээн зөвшөөрөхүйц нисэхийн өгөгдөл;</p> <p>(3) тухайн хэрэглэлийн нисклгийн журам хүчинтэй болох төлөвлөсөн хугацаа;</p> <p>(4) тухайн хэрэглэлийн нисклгийн журам нь энэ Дүрэмд заасан холбогдох стандарт болон шаардлагыг хангаж байгааг бататгах 173.59(b)(1)-д заасан удирдах ажилтан гарын үсэг зурсан мэдэгдэл;</p> <p>(5) хэрэглэлийн нисклгийн журамд 173.63-т шаардсан байгууллагын журмын дагуу засвар, өөрчлөлт хийхээ бататгаж, холбогдох ХНЖҮБ-ын удирдах ажилтан гарын үсэг зурсан мэдэгдэл.</p> <p>(d) Энэ зүйлийн (с)(5)-ын зорилгоор, тухайн ХНЖҮБ нь энэ Дүрмийн дагуу гэрчилгээжсэн байгууллага байх ба түүний гэрчилгээнд тодорхой хэрэглэлийн нисклгийн журмын төрлийг зохиох, нисклгээр баталгаажуулах, гэрчилгээжүүлэх болон засвар өөрчлөлт хийх эрхийг олгоно.</p>		<p>нөхөж оруулсан</p>
	<p>173.61 Нисклгийн журмыг гэрчилгээжүүлэх ажилтны эрх</p> <p>(а) Нисклгийн журам энэ дүрмийн Г.Бүлэгт заасан холбогдох бүх шаардлагад нийцэж, тэдгээрийн дагуу зохиогдсоныг бататгах чадвартай, энэ дүрмийн Хавсралт А-д заасан шаардлагыг хангасан ажилтанд ИНЕГ-аас Нисклгийн журмыг гэрчилгээжүүлэх эрх олгож, гэрчилгээжүүлэх Нисклгийн журмын төрлийг заана.</p>	
<p>173.63. Хэрэглэлийн нисклгийн журамд <u>засвар өөрчлөлт хийх</u></p> <p>(а) <u>ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> 173.61(с)(5)-д шаардсан мэдэгдлийн дагуу, тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд засвар өөрчлөлт хийх хэрэглэлийн нисклгийн журам бүрд энэ Дүрмийн шаардлагын дагуу засвар өөрчлөлт хийдэг байх журмыг тогтоосон байх үүрэгтэй.</p>	<p>173.63 Хэрэглэлийн нисклгийн журмыг <u>зарлах</u></p> <p>(а) <u>Нисклгийн журмын үйлчилгээний байгууллага нь</u> дараах нөхцөлүүд хангагдсан тохиолдолд ИНД-175-ын дагуу гэрчилгээжсэн байгууллагад мэдээлэл хүргүүлэх журамтай байна:</p> <p>1/ <u>энэ зүйлийн (в)-д заасны дагуу шаардлагатай мэдээллээр ИНЕГ-ын даргыг хангах;</u></p> <p>2/ <u>Нисклгийн журмыг агаарын навигацийн бүртгэлд оруулаагүй тохиолдолд ашиглалтанд зориулан</u></p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>(b) Энэ зүйлийн (а)-д шаардсан журам нь <u>дараах тохиолдолд дүн шинжилгээ хийх хэрэв шаардлагатай бол нислэгээр баталгаажуулах хэрэглэлийн нислэгийн журам бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан байх ёстой:</u></p> <p>(1) тухайн хэрэглэлийн нислэгийн журам нь энэ Дүрмийн холбогдох стандарт болон шаардлагыг үргэлжлүүлэн хангаж байгааг бататгах <u>тогтоосон хугацааны дагуу;</u></p> <p>(2) хэрэв 173.53(а)(2)-т заасан аливаа өгөгдөлд, хэрэглэлийн нислэгийн журмын <u>үнэн зөв байдалд нөлөөлж болох өөрчлөлт орсон бол.</u></p> <p>(c) Энэ зүйлийн (а)-д шаардсан журамд хэрэглэлийн нислэгийн журам бүрийн засвар өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх хугацаа хоорондын үечлэлийг тогтоох, эсхүл өөрчлөх үндэслэл болон шалгуурыг багтааж баримтжуулсан байх ёстой.</p>	<p><u>гаргахгүй байх.</u></p> <p>(б) Энэ зүйлийн (а)-д заасан журам нь дараах зүйлсийг агуулсан байна:</p> <p>1/ нислэгийн мэдээллийн үйлчилгээний байгууллагатай хамтран Нислэгийн журмыг нислэгийн мэдээллийн эмхэтгэлд хэвлэх талаарх зохицуулалтын арга хэлбэр;</p> <p>2/ энэ зүйлийн (а)-д заасан журмын дагуу хүргүүлсэн Нислэгийн журам, эсхүл түүнд орсон аливаа өөрчлөлт нь нислэгийн <u>мэдээллийн эмхэтгэлд үнэн зөв хэвлэгдсэнийг шалгах арга хэлбэр.</u></p> <p>(в) <u>Нислэгийн мэдээллийн эмхэтгэлд орж буй Нислэгийн журам бүрийн талаар ИНЕГ-ын даргад дараах мэдээллийг хүргүүлнэ:</u></p> <p>1/ <u>тухайн Нислэгийн журмыг бусад журмаас ялгаж таних зөвшөөрөгдсөн нэр болон бусад төрлийн таних тэмдэг;</u></p> <p>2/ <u>Нислэгийн журмыг тодорхойлсон буюу дүрсэлсэн нислэгийн өгөгдөл;</u></p> <p>3/ <u>Нислэгийн журмыг хүчин төгөлдөр болгохоор төлөвлөсөн огноо;</u></p> <p>4/ <u>173.59 (б) 1/-д зааснаар тухайн Нислэгийн журам нь дүрмийн шаардлагыг хангаж буйг нотлох баримт;</u></p> <p>5/ <u>Нислэгийн журмын боловсруулалт нь 173.65 (а)-д заасан журмын дагуу хийгдсэнийг нотлох баримт.</u></p>	
<p>173.65. <u>Хэвлэн нийтэлсэн хэрэглэлийн нислэгийн журмын алдаа</u></p> <p>(а) <u>ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд гэрчилгээжүүлсэн, эсхүл засвар өөрчлөлт хийсэн хэрэглэлийн нислэгийн журамд илэрсэн энэ Дүрмийн <u>стандарт</u> шаардлагад нийцээгүй аливаа алдаа үл тохирол, эсхүл болзошгүй үл тохирлыг ИНД-12-ын дагуу бүртгэх, шинжлэн шалгах, залруулах болон мэдээлэх журмыг тогтоосон байх үүрэгтэй.</p> <p>(b) Энэ зүйлийн (а)-д шаардсан журам нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:</p> <p>(1) хэрэв энэ зүйлийн (а)-д заасан алдаа, эсхүл үл тохирол нь агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болох бол, үйл ажиллагаанд</p>	<p>173.67 Нислэгийн журмын алдааг <u>залруулах</u></p> <p>(а) Нислэгийн журмын үйлчилгээний байгууллага нь гэрчилгээжүүлсэн болон боловсруулсан Нислэгийн журамд тусгагдсан шалгуур болон шаардлагад нийцээгүй аливаа алдаа, үл тохирол, эсхүл болзошгүй үл тохирлыг бүртгэх, шинжлэн судлах, залруулах журамтай байна.</p> <p>(б) Энэ зүйлийн (а)-д заасан <u>алдаа, үл тохирол илэрсэн тохиолдолд дараах арга хэмжээг авна:</u></p> <p>1/ алдаа болон үл тохирол нь агаарын хөлгийн аюулгүй үйл ажиллагаанд нөлөөлөх буюу нөлөөлж болзошгүй тохиолдолд <u>яаралтай ашиглалтаас</u></p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>ашиглахаас сэргийлж <u>нэн даруй хурааж авдаг байх</u>;</p> <p>(2) 173.57-д заасны дагуу зохих ёсоор эрх олгогдсон удирдах ажилтан алдаа, эсхүл <u>үл тохирлыг залруулж</u>, гэрчилгээжүүлдэг байх;</p> <p>(3) энэ зүйлийн (b)(2)-т шаардсан залруулгыг ойлгомжтой тодорхойлдог байх ба тухайн алдаа эсхүл үл тохирлын үйл ажиллагааны ач холбогдлын чухлаас нь шалтгаалан <u>хамгийн тохиромжтой арга хэлбэрээр түгээдэг байх</u>;</p> <p>(4) тухайн алдаа, эсхүл үл тохирлын эх сурвалжийг таньж тогтоодог байх, ба:</p> <p>(i) хэрэв боломжтой бол дахин давтагдахаас урьдчилан сэргийлж устгадаг байх;</p> <p>(ii) алдаа, эсхүл үл тохирлын эх сурвалж нь бусад хэрэглэлийн нислэгийн журмын <u>үнэн зөв байдалд</u> нөлөөлөхгүй болохыг бататгах урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг байх;</p> <p>(5) энэ зүйлийн (a)-д заасан алдаа, эсхүл үл тохиролтой холбоотой <u>түгээгдсэн</u> мэдээллийн зөрчлийн талаар ИНД-12-ын дагуу эрх бүхий байгууллагад мэдээлдэг байх.</p>	<p>гаргана;</p> <p>2/ алдаа болон үл тохирлыг залруулсны дараа 173.61-ийн дагуу эрх олгогдсон ажилтан гэрчилгээжүүлнэ;</p> <p>3/ алдаа болон үл тохирлын нөлөөнөөс хамааран энэ зүйлийн 2/-т дурьдсан <u>залруулгыг зарлах арга хэлбэрийг нарийвчлан тогтооно</u>;</p> <p>4/ алдаа болон үл тохирлын эх сурвалжийг тогтоож:</p> <p>4.1 алдаа болон үл тохирол дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх, боломжтой бол устгах;</p> <p>4.2 алдаа болон үл тохирлын эх сурвалж нь бусад ямар нэгэн Нислэгийн журмын <u>бүтцэд</u> нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.</p> <p>5/ энэ зүйлийн (a)-д дурьдсан алдаа болон үл тохиролтой холбоотой <u>зарлагдсан</u> мэдээллийн талаар ИНД-12-ын дагуу холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх.</p>	
<p>173.67. <u>Бүртгэл</u></p> <p>(a) <u>ХНЖҮБ-ын</u> гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь хэрэглэлийн нислэгийн журам зохиох, гэрчилгээжүүлэх болон засвар өөрчлөлт хийхтэй холбоотой тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бүртгэл хөтлөх журмыг тогтоосон байх үүрэгтэй.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу бүртгэл хөтлөх ажиллагаа нь бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, хамгаалах, ашиглахад <u>бэлэн байлгах, засвар өөрчлөлт</u> хийх болон устгах ажиллагааг байна.</p> <p>(c) Энэ зүйлийн (a)-д шаардсан журам нь 173.59-ийн дагуу гэрчилгээжүүлсэн болон 173.63-ын дагуу засвар өөрчлөлт хийсэн хэрэглэлийн нислэгийн журмыг бүртгэхэд шаардлагатай дараах мэдээллийг багтаасан байх ёстой:</p> <p>(1) хэрэглэлийн нислэгийн журмын хувьд, 173.61(c)-д шаардсан дэлгэрэнгүй мэдээлэл;</p> <p>(2) 173.55-ын дагуу зохиосон хэрэглэлийн нислэгийн журмын зохиолтыг бататгах, <u>нэмэлт өөрчлөлт хийх, баталгаажуулах, баталгаажуулаагүй үндэслэл</u> болон гэрчилгээжүүлэх ажиллагааг багтаасан гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй бусад дэлгэрэнгүй мэдээлэл;</p>	<p>173.69 <u>Бүртгэл хөтлөлт</u></p> <p>(a) Нислэгийн журмын үйлчилгээний байгууллага нь Нислэгийн журмыг зохиох, боловсруулах болон гэрчилгээжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны бүртгэл хөтлөх журамтай байна.</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-д заасан бүртгэлд, бүртгэлийн нэр, бүрдүүлэлт, индексжүүлэлт, хадгалалт, хамгаалалт, ашиглах боломж болон устгал орно.</p> <p>(в) Энэ зүйлийн (a)-д заасан журамд доорх зүйлсийн бүртгэл хөтлөхөд тавигдах шаардлага тусгагдсан байна:</p> <p>1/ 173.63 (в)-д заасан Нислэгийн журмын мэдээлэл;</p> <p>2/ Нислэгийн журам зохиох, нислэгээр батлах, <u>батлагдаагүй бол шалтгаан</u>, гэрчилгээжүүлэлт, үйл ажиллагааны тухай бусад мэдээлэл;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>- Amend.2-оор нэмэгдсэн</p>

<p>(3) түгээх болон шалгах ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл; (4) 173.65-ын дагуу хэрэглэлийн нислэгийн журмын алдаа болон үл тохиролд авсан арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээлэл; (5) 173.63-т шаардсан журмын дагуу засвар өөрчлөлтийн дүн шинжилгээ болон нислэгээр баталгаажуулалт хийсэн дэлгэрэнгүй мэдээлэл.</p> <p>(d) Энэ зүйлийн (а)-д шаардсан журам нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:</p> <p>(1) дараах ажилтны мэргэшил, туршлага, сургалт үнэлгээ хэрэв хамааралтай бол эрхийн дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан бүртгэл.</p> <p>(i) 173.51(а)(2)-т шаардсан бүх <u>удирдах</u> ажилтан; (ii) 173.51(а)(3)-т шаардсан ажилтнууд;</p> <p>(2) [хүчингүй]</p> <p>(3) энэ зүйлийн (с) болон (d)-д шаардсан <u>гаргацтай, үнэн зөв, байнгын</u> арилдаггүй гаргацтай <u>форматаар</u> сэргээх боломжтой бүртгэл; (4) энэ зүйлийн (с)-д шаардсан холбогдох хэрэглэлийн нислэгийн журмыг хэрэглээнээс хурааж авснаас хойш 5 жилээс доошгүй хугацаагаар хадгалдаг байх бүртгэл.</p>	<p>3/ зарлах болон шалгах үйл ажиллагааны мэдээлэл; 4/ Нислэгийн журамд илэрсэн алдаа болон үл тохирлын дагуу 173.67-ын хүрээнд авсан аливаа арга хэмжээний тухай мэдээлэл; 5/ 73.65-д заасны дагуу боловсруулагдсан болон нислэгээр батлагдсан мэдээлэл.</p> <p>(г) Энэ зүйлийн (а)-д заасан журамд дараах шаардлагууд тусгагдсан байна:</p> <p>1/ дараах ажилтны мэргэшил, туршлага, сургалт, үнэлгээ болон шаардлагатай тохиолдолд олгогдсон эрхийн талаарх мэдээллийг багтаасан бүртгэл хөтлөх:</p> <p>1.1 173.51 (а) 2/-т заасан албан тушаалтан буюу ажилтан; 1.2 173.51 (а) 3/-т заасан ажилтан.</p> <p>2/ <u>173.71-д заасны дагуу гүйцэтгэсэн бүх аюулгүй ажиллагааны удирдлагын дүн шинжилгээний бүртгэл хөтлөх;</u></p> <p>3/ энэ зүйлийн (в) болон (г)-д шаардсан бүртгэл нь баталгаажсан маягтын дагуу уншихад ойлгомжтой, үнэн зөв, ашиглахад хялбар байх; 4/ энэ зүйлийн (в)-д заасан бүртгэлийг холбогдох Нислэгийн журам хэрэглээнээс гарснаас хойш 5-аас доошгүй жилийн хугацаагаар хадгалах.</p>	
<p>173.69. Аюулгүй байдлын удирдлага <u>ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-100.3-ын дагуу аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон үйл ажиллагаандаа мөрддөг байх үүрэгтэй.</u></p>		<p>- Amend.2-оор нэмэгдсэн</p>
<p>173.71. ХНЖҮБ-ын Ерөнхий заавар</p> <p>(а) <u>ХНЖҮБ-ын</u> гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг багтаасан <u>Ерөнхий</u> зааврыг Даргад хүргүүлэх үүрэгтэй:</p> <p>(1) <u>Ерөнхий</u> заавар болон түүнд багтсан бусад заавар нь дараах шаардлагыг хангасан болохыг бататган, хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс <u>Гүйцэтгэх захирал</u> гарын үсэг зурсан мэдэгдэл:</p> <p>(i) тухайн байгууллагыг тодорхойлох ба энэ Дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулах; (ii) хүсэлт гаргагчийн байгууллагын ажилтнууд түүнийг байнга</p>	<p>173.73 Байгууллагын <u>Үйл ажиллагааны</u> зааварт тавигдах шаардлага</p> <p>(а) Нислэгийн журмын үйлчилгээний байгууллага нь дараах зүйлүүдийг тусгасан <u>үйл ажиллагааны</u> зааврыг ИНЕГ-ын даргад ирүүлнэ:</p> <p>1/ <u>Үйл ажиллагааны</u> заавар болон түүнд орсон аливаа баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан болохыг нотолсон баримт:</p> <p>1.1 <u>Үйл ажиллагааны</u> заавартаа нийцсэн үйл ажиллагааг явуулна гэдгийг бататгах арга хэлбэр;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан - Amend.2-оор нэмэгдсэн</p>

- дагаж мөрддөг байх;
- (1A) 173.69-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хувьд:
(i) ИНД-100.3(б)-д шаардсан бүх баримт бичиг;
(ii) ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчийн хувьд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхийг дүрслэн харуулсан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;
- (2) 173.51(а)(2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын албан тушаал болон нэр;
- (3) 173.51(а)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын дараах үүрэг, хариуцлагын дэлгэрэнгүй мэдээлэл:
(i) тухайн байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харьцах тэдний хариуцсан асуудал;
(ii) аюулгүй байдлын удирдлагын үүрэг хариуцлага;
- (4) хэрэв энэ хэсгийн (2)-ын дагуу нэгээс дээш удирдах ажилтан байгаа бол удирдах ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;
- (4A) байгууллагын хүрээнд аюулгүй байдлын хариуцлагын шугаман хамаарлыг тодорхойлсон мэдээлэл;
- (5) хэрэглэлийн нислэгийн журмыг гэрчилгээжүүлэх 173.57-гийн дагуу эрх олгогдсон удирдах ажилтан бүрийн нэр;
- (6) энэ хэсгийн (5)-д заасан ажилтан бүрд олгосон эрхийн цар хүрээний дэлгэрэнгүй мэдээлэл;
- (7) хүсэлт гаргагчийн байгууллагын зохиодог гэрчилгээжүүлдэг, эсхүл засвар өөрчлөлт хийдэг хэрэглэлийн нислэгийн журмын төрлийн жагсаалт;
- (8) 173.53(а)-гийн заасан дараах шаардлагыг хангах хүсэлт гаргагчийн аргачлалын дэлгэрэнгүй мэдээлэл:
(i) төхөөрөмж;
(ii) холбогдох хүчинтэй өгөгдлийг ашиглах;
(iii) холбогдох баримт бичгийн хувийг ашиглах;
- (9) нислэгээр баталгаажуулах шаардлагагүй хэрэглэлийн нислэгийн журмын 173.53(б)-гийн шаардлагыг хангах хүсэлт гаргагчийн аргачлалын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (10) дараах зүйлд шаардсан хүсэлт гаргагчийн журмын дэлгэрэнгүй мэдээлэл:

1.2 ажилтнуудыг Үйл ажиллагааны заавар, Иргэний нисэхийн багц дүрэм болон бусад баримт бичигт заасан шаардлагад нийцэж ажиллахыг шаардсан.

- 2/ 173.51(а) 2/-т заасан албан тушаалтан болон ажилтны нэрс;
- 3/ энэ зүйлийн 2/-т заасан албан тушаалтан болон ажилтны үүрэг хариуцлага, байгууллагыг төлөөлж ИНЕГ-ын даргатай шууд харьцах асуудал;
- 4/ албан тушаалтан болон ажилтны үүрэг хариуцлагын уялдааг үзүүлсэн бүтэц зохион байгуулалтын бүдүүвч;
- 5/ 173.61-д заасны дагуу Нислэгийн журмыг гэрчилгээжүүлэх эрх бүхий ажилтны нэрс;
- 6/ энэ зүйлийн 5/-д заасан ажилтны эрх үүргийн талаарх мэдээлэл;
- 7/ Нислэгийн журмын үйлчилгээний байгууллагаас зохиох, боловсруулах, гэрчилгээжүүлэх Нислэгийн журмын жагсаалт;
- 8/ өргөдөл гаргагч нь дараах зүйлстэй холбоотой 173.53 (а)-д заасан шаардлагыг хэрхэн хангаж буй талаар:
8.1 тоног төхөөрөмж;
8.2 холбогдох болон хүчин төгөлдөр өгөгдлийг ашиглах боломж;
8.3 холбогдох баримт бичгийн хувийг ашиглах боломж;
- 9/ Нислэгийн журмын үйлчилгээний байгууллага нь нислэгээр батлах шаардлагагүй Нислэгийн журамтай холбогдуулан 173.53 (б)-д заасан шаардлагыг хэрхэн хангасан тухай;
- 10/ энэ дүрмийн дагуу Нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын боловсруулсан дараах

<p>(i) 173.51(b) - ажилтны ур чадварын хадгалалтын үнэлгээний талаар;</p> <p>(ii) 173.53(b)(1) - өгөгдлийг ашиглах талаар;</p> <p><u>(iii) 173.53(b)(2) - өгөгдлийн хүчинтэй байдал ба нарийвчлалын талаар</u></p> <p>(iv) 173.53(c) - баримт бичгийн хяналтын талаар;</p> <p>(v) 173.55(a) - хэрэглэлийн нислэгийн журам зохиох, зохиолтыг бататгах болон нислэгээр баталгаажуулах талаар;</p> <p>(vi) 173.55(c) - хэрэглэлийн нислэгийн журмыг нислэгээр баталгаажуулах талаар;</p> <p>(vii) <u>173.55(e) - нислэгээр баталгаажуулах шаардлагагүй хэрэглэлийн нислэгийн журмын үндэслэлийн талаар;</u></p> <p><u>(viii) 173.55(f), эсхүл (g) - стандартыг дагаж мөрдөх талаар;</u></p> <p><u>(ix) 173.57 - удирдах ажилтны эрхийн талаар;</u></p> <p><u>(x) 173.59 - хэрэглэлийн нислэгийн журмын гэрчилгээжүүлэлтийн талаар;</u></p> <p><u>(xi) 173.61 - хэрэглэлийн нислэгийн журмыг түгээх болон Даргад журам бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлэх аргачлалын талаар;</u></p> <p><u>(xii) 173.63 - хэрэглэлийн нислэгийн журамд засвар өөрчлөлт хийх талаар;</u></p> <p><u>(xiii) 173.65 - хэвлэн нийтэлсэн хэрэглэлийн нислэгийн журмын алдааны талаар;</u></p> <p>(xiv) 173.67 - бүртгэл хөтлөлтийн талаар;</p> <p>(11) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх журам.</p> <p>(b) Хүсэлт гаргагчийн <u>Ерөнхий</u> заавар нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.</p>	<p>журмын талаарх мэдээлэл:</p> <p>10.1 ажилтны ур чадварыг <u>үнэлэх, дадлагажуулах</u> болон ур чадварыг <u>хадгалах</u> журам /173.51 (б) заалт/;</p> <p>10.2 өгөгдлийг ашиглах журам /173.53 (б) заалт/;</p> <p>10.3 баримт бичгийн <u>хяналтын</u> журам /173.53 (а) заалт/;</p> <p>10.4 Нислэгийн журам зохиох болон шалгаж батлах журам /173.55 (а) заалт/;</p> <p>10.5 Нислэгийн журмыг нислэгээр батлах журам /173.57 (в) заалт/;</p> <p>10.6 Нислэгийн журмыг гэрчилгээжүүлэх журам /173.59 (а) заалт/;</p> <p>10.7 <u>мэдээлэл хүргүүлэх журам /173.63(а) заалт/;</u></p> <p><u>10.8 Нислэгийн журмын боловсруулалтын журам /173.65 (а) заалт/;</u></p> <p><u>10.9 зөрчил болон үл тохирлыг бүртгэх, шинжлэн судлах, залруулах агурам /173.67 (а) заалт/;</u></p> <p>10.10 бүртгэл хөтлөлтийн журам /173.69 (а) заалт/;</p> <p>10.11 <u>аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны журам /173.71 заалт/.</u></p> <p>11/ <u>Үйл ажиллагааны</u> зааврыг хянах, боловсруулах болон түгээх журмууд.</p> <p>(б) Энэ зүйлийн (а)-д заасан байгууллагын <u>Үйл ажиллагааны</u> заавар нь <u>ИНЕГ</u>-ын даргаар хүлээн зөвшөөрөгдсөн байна.</p>	
	<p>173.71 <u>Аюулгүй ажиллагааны удирдлагын</u></p>	

ТОГТОЛЦООНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

(а) Нислэгийн журмын үйлчилгээний байгууллага нь энэ дүрэмд заасан журмыг дагаж мөрдөх бөгөөд шаардлага хангаж буйг бататгах аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог бий болгосон байна.

(б) Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоонд дараах зүйлсийг багтаана:

1/ ИНД-12-ын дагуу хэрэг явдлыг мэдээлэх журмыг багтаасан аюулгүй ажиллагааны соёл болон аюулгүй ажиллагааны журмыг боловсруулахтай холбоотой аюулгүй ажиллагааны бодлого;

2/ аюулгүй ажиллагааны үзүүлэлтийг тогтоох болон ажиглалт хийх журам;

3/ тогтолцоо болон үйл явцын хүрээнд гарч болзошгүй зөрчлийг илрүүлэх журам;

4/ Нислэгийн журмын бүтцэд нөлөөлж болзошгүй эрсдлийг хянах болон бууруулах журам;

5/ илрүүлсэн зөрчлийг шинжлэн шалгах, задлан шинжилгээ хийх болон илэрсэн зөрчлийн шалтгааныг арилгахыг бататгах, залруулах ажиллагааны журам;

6/ гарч болзошгүй зөрчлийн шалтгааныг арилгаж, сайжруулж буйг бататгах урьдчилан сэргийлэх ажиллагааны журам;

7/ Үйл ажиллагааны заавар, аюулгүй ажиллагааны бодлого болон журмандаа нийцсэн ажиллагаа явуулж байгааг шалгах дотоод аудитын хөтөлбөр;

8/ энэ дүрмийн дагуу аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны нийцтэй, үр дүнтэй байдлыг бататгах статистикийн задлан шинжилгээг ашиглах талаарх удирдлагын дүн шинжилгээний журам;

9/ аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог баримтжуулах, эрсдлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой мэдээллээр хангах (энэ зүйлийн (б) 1/-ээс 8/-д заасан журам), мөн байгууллагад учирч болзошгүй томоохон аюулыг бүртгэх болон түүнийг хянах аюулгүй ажиллагааны удирдлагын гарын авлагатай байх.

(в) Нислэгийн журмын үйлчилгээний байгууллага нь аюулгүй ажиллагааны удирдлагын журамдаа аюулгүй ажиллагааны бодлогыг байгууллагын бүх ажилтанд танилцуулах, хэрэгжүүлэх, мөн хадгалалтыг бататгах арга хэлбэрийг тусгасан байна.

(г) Энэ зүйлийн (б) 5/-д заасан, залруулах ажиллагааны журам нь дараах зүйлсийг агуулсан байна:

- 1/ илэрсэн зөрчлийг хэрхэн залруулах талаар;
- 2/ хэрэглэлийн нислэгийн журмын бүтцэд нөлөөлсөн болон нөлөөлж болзошгүй нөхцөл байдлыг тодорхойлох талаар;
- 3/ залруулах ажиллагааны үр дүнг бататгах дараагийн шатны арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар;
- 4/ энэ дүрэмд заасан аливаа журамд залруулах ажиллагааны үр дүнд гарсан өөрчлөлтийг хэрхэн тусгах талаар;
- 5/ залруулах ажиллагааны үр дүнтэй байдлыг удирдлагын зүгээс хэрхэн үнэлэх талаар.

(д) Энэ зүйлийн (б) 6/-д заасан урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам нь дараах зүйлсийг бататгана:

- 1/ гарч болзошгүй зөрчлийг хэрхэн залруулах;
- 2/ тогтоогдсон, гарч болзошгүй зөрчлийн шалтгаан, түүний үр дүнг хэрхэн тодорхойлох;
- 3/ урьдчилан сэргийлэх ажиллагаа үр дүнтэй болохыг бататгах дараагийн шатны арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх;
- 4/ энэ дүрэмд заасан аливаа журамд урьдчилан сэргийлэх ажиллагааны үр дүнд гарсан өөрчлөлтийг хэрхэн тусгах;
- 5/ урьдчилан сэргийлэх ажиллагааны үр дүнтэй байдлыг удирдлагын зүгээс хэрхэн үнэлэх.

(е) Энэ зүйлийн (б) 7/-д заасан дотоод аудитын хөтөлбөр нь:

- 1/ үйл ажиллагааны онцлогийг харгалзан үзсэний үндсэн дээр аудит хийх давтамж болон байршлыг заана;
- 2/ аудит шалгалтыг ажиллагаанд хамааралгүй мэргэшсэн ажилтнаар гүйцэтгүүлэхийг шаардана;
- 3/ аудит шалгалтын үр дүн, үйл ажиллагааг хариуцсан ажилтан болон дотоод аудитуудыг хариуцсан удирдах ажилтанд тайлагнахыг шаардана;
- 4/ өмнө нь хийгдсэн аудит шалгалтаас хойш үйл ажиллагааг хариуцсан ажилтны авсан аливаа урьдчилан сэргийлэх болон залруулах үйл ажиллагааны байдлыг үнэлнэ;
- 5/ аудит шалгалтаар зөрчил илэрсэн тохиолдолд хариуцсан ажилтны зүгээс урьдчилан сэргийлэх болон залруулах ажиллагаа явуулахыг шаардана;

	<p>6/ аливаа урьдчилан сэргийлэх болон залруулах үйл ажиллагааны үр дүнд дүн шинжилгээ хийх дараагийн шатны аудитын нөхцөлийг бүрдүүлж өгнө.</p> <p>(ж) Энэ зүйлийн (б) 8/-д заасан удирдлагын дүн шинжилгээний журам нь:</p> <p>1/ аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдлын шаардлагыг харгалзан үзсэний үндсэн дээр удирдлагын дүн шинжилгээний давтамжийг заана;</p> <p>2/ удирдлагын дүн шинжилгээ хариуцсан удирдах ажилтныг томилно;</p> <p>3/ дүн шинжилгээний үр дүнг үнэлэх болон бүртгэхийг шаардана.</p> <p>(з) Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хариуцсан удирдах ажилтан нь аливаа Нислэгийн журмын бүтцэд нөлөөлөх асуудлаар удирдах албан тушаалтантай шууд харьцах эрхтэй байна.</p>	
<p>С Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага</p>	<p>В. БҮЛЭГ – ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА</p>	
<p>173.101. <u>Байнгын хэрэгжилт</u> <u>ХНЖҮБ-ын</u> гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:</p> <p>(1) 173.71-д шаардсан гэрчилгээ эзэмшигчийн <u>Ерөнхий</u> зааврын нэгээс доошгүй хүчинтэй, бүрэн хувийг гэрчилгээ эзэмшигчийн үндсэн ажлын байрлалд хадгалдаг байх;</p> <p>(2) <u>Ерөнхий</u> заавартаа дэлгэрэнгүй заасан бүх журам болон стандартыг дагаж мөрддөг байх;</p> <p>(3) <u>Ерөнхий</u> зааврын холбогдох бүлгийг шаардлагатай ажилтан ажил үүргээ гүйцэтгэхдээ ашиглах боломжтой байлгах;</p> <p>(4) энэ Дүрмийн дагуу гэрчилгээжүүлэлтэд тогтоосон В Бүлгийн шаардлага болон стандартыг байнга хангадаг байх;</p> <p>(5) гэрчилгээ эзэмшигчийн шуудангийн хаяг, үйлчилгээ эрхлэх хаяг, утасны дугаар, эсхүл факсын дугаарын аливаа өөрчлөлтийг тухайн өөрчлөлт орсноос хойш 28 хоногийн дотор Даргад мэдэгддэг байх.</p>	<p>173.101 <u>Ерөнхий шаардлага</u></p> <p>(а) Гэрчилгээ эзэмшигч нь дараах үндсэн шаардлагыг биелүүлнэ:</p> <p>1/ 173.73 (а)-д заасан <u>Үйл ажиллагааны</u> зааврын хүчин төгөлдөр хувийг ажлын байрны нэгж бүрт байршуулах;</p> <p>2/ <u>Үйл ажиллагааны</u> зааварт тусгагдсан журам, шалгуурыг мөрдөж ажиллах;</p> <p>3/ энэ дүрмийн В Бүлгийн шаардлагыг байнга мөрдөж ажиллах;</p> <p>4/ гэрчилгээ эзэмшигчийн шуудангийн хаяг, үйлчилгээний хаяг, утасны дугаар болон факсын дугаар өөрчлөгдсөн тохиолдолд 28 хоногийн дотор <u>ИНЕГ</u>-ын даргад мэдэгдэнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>173.103. <u>Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт</u></p> <p>(а) <u>ХНЖҮБ-ын</u> гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:</p> <p>(1) энэ зүйлийн (b)-г харгалзан <u>Ерөнхий</u> зааврын нэмэлт өөрчлөлтийг тухайн байгууллагын тодорхойлолт хүчинтэй хэвээр хадгалагдаж байхаар хийдэг болохыг бататгах;</p> <p>(2) <u>Ерөнхий</u> зааварт оруулсан нэмэлт өөрчлөлт нь энэ Дүрмийн холбогдох шаардлагад нийцсэн болохыг бататгах;</p>	<p>173.103 <u>Үйл ажиллагааны зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах</u></p> <p>(а) Гэрчилгээ эзэмшигч нь Нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтад орсон өөрчлөлтийг <u>Үйл ажиллагааны</u> заавартаа тусган хэрэгжүүлнэ.</p> <p>(б) Гэрчилгээ эзэмшигчийн <u>Үйл ажиллагааны</u> зааварт оруулсан өөрчлөлт нь дүрмийн шаардлага болон <u>Үйл</u></p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>- Amend.2-оор нэмэгдсэн</p>

<p>(3) <u>Ерөнхий</u> зааварт заасан нэмэлт өөрчлөлт оруулах журмыг дагаж мөрдөх;</p> <p>(4) <u>Ерөнхий</u> заавартаа нэмэлт өөрчлөлт оруулсны дараа гэрчилгээ эзэмшигч нь <u>Ерөнхий</u> заавартаа оруулсан нэмэлт өөрчлөлтийн хувийг Даргын <u>хэрэгцээнд зориулж цаг алдалгүй хүргүүлэх</u>;</p> <p>(5) <u>нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж Даргын үзсэн нэмэлт өөрчлөлтийг Ерөнхий заавартаа оруулах</u>.</p> <p>(b) <u>ХНЖҮБ-ын</u> гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлтийг хийхийн өмнө Даргын зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагатай:</p> <p>(1) Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон ажилтан:</p> <p>(2) 173.71(а)(2)-т шаардсан <u>Ерөнхий</u> зааварт заасан удирдах ажилтны нэр, эсхүл албан тушаал:</p> <p>(3) тухайн эзэмшигчийн гэрчилгээнд заасан хэрэглэлийн нислэгийн журмын төрөл:</p> <p>(4) <u>аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, хэрэв тухайн өөрчлөлт нь бодит өөрчлөлт бол</u>.</p> <p>(c) Энэ зүйлийн (b)-д заасан өөрчлөлтийг хийж байх үед, эсхүл түүнийг хийсний дараа тухайн хэрэглэлийн нислэгийн журмын гэрчилгээ эзэмшигчийн дагаж мөрдөх ёстой нөхцөлийг Дарга тогтоож болно.</p> <p>(d) Хэрэглэлийн нислэгийн журмын гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (c)-гийн дагуу Даргын тогтоосон нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.</p> <p>(e) Хэрэв энэ зүйлийн (b)-д заасан өөрчлөлт нь хэрэглэлийн нислэгийн журмын гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардаж байгаа бол, гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд тухайн өөрчлөлтийг баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр Даргад цаг алдалгүй хүргүүлэх үүрэгтэй.</p>	<p><u>ажиллагааны</u> зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах журамд нийцэж байна.</p> <p>(в) Гэрчилгээ эзэмшигч нь <u>Үйл ажиллагааны</u> заавартаа оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээллээ <u>ИНЕГ</u>-ын даргад <u>ирүүлнэ</u>.</p> <p>(г) Гэрчилгээ эзэмшигч нь <u>Үйл ажиллагааны</u> заавартаа дараах өөрчлөлтүүдийг оруулах тохиолдолд <u>ИНЕГ</u>-ын даргад урьдчилан мэдэгдэнэ:</p> <p>1/ <u>удирдах</u> албан тушаалтан <u>өөрчлөгдөх</u>;</p> <p>2/ <u>удирдах</u> ажилтнууд өөрчлөгдөх;</p> <p>3/ гэрчилгээнд заасан Нислэгийн журмын төрөл өөрчлөгдөх.</p> <p>(д) <u>ИНЕГ</u>-ын дарга нь энэ зүйлийн (г)-д зааснаар <u>Үйл ажиллагааны</u> зааварт өөрчлөлт орох явцад үйл ажиллагаа явуулах нөхцөлийг тусгайлан тогтоож өгч болно.</p> <p>(е) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (д)-д заасны дагуу <u>ИНЕГ</u>-ын даргын тогтоосон нөхцөлийг дагаж мөрдөнө.</p> <p>(ж) Энэ зүйлийн (г)-д зааснаар гэрчилгээнд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа тохиолдолд гэрчилгээг <u>ИНЕГ</u>-ын даргад ирүүлнэ.</p> <p>(з) Гэрчилгээ эзэмшигч нь <u>ИНЕГ</u>-аас нисэхийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс оруулж буй нэмэлт, өөрчлөлтүүдийг Үйл ажиллагааны заавартаа тусгана.</p>	
<p>173.105. <u>Хэрэглэлийн</u> нислэгийн журмын <u>засвар өөрчлөлтийг зогсоох</u> Хэрэв <u>ХНЖҮБ-ын</u> гэрчилгээ эзэмшигч нь 173.<u>63</u>-т шаардсаны дагуу хэрэглэлийн нислэгийн журамд хийдэг тухайн засвар өөрчлөлтийг цаашид зогсоохоор төлөвлөж байгаа бол, гэрчилгээ эзэмшигч нь тухайн засвар өөрчлөлтийг хийхээ зогсоохоос 90-ээс доошгүй хоногийн өмнө саналаа Даргад бичгээр мэдэгдэх үүрэгтэй.</p>	<p>173.105 Нислэгийн журамд <u>нэмэлт</u>, өөрчлөлт оруулахыг зогсоох (а) Гэрчилгээ эзэмшигч нь 173.<u>65</u>-д зааснаар Нислэгийн журмын боловсруулалтыг зогсоох тохиолдолд үйлчилгээгээ зогсоохоос 90 хоногийн өмнө саналаа <u>ИНЕГ</u>-ын даргад бичгээр ирүүлнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p><u>Д Бүлэг - Хэрэглэлийн нислэгийн журам зохиох шалгуур</u></p>	<p>Г БҮЛЭГ. <u>НИСЛЭГИЙН ЖУРАМ ЗОХИОХ</u></p>	

	<p>173.151 Нислэгийн журам зохиох шалгуур</p> <p>(а) Нислэгийн журам бүрийг Иргэний нисэхийн холбогдох дүрэм, стандарт, заавар болон нислэгийн өгөгдлийн чанарын шаардлагад нийцүүлэн зохионо. Үүнд:</p> <p>1/ ICAO-ийн баримт бичгүүд:</p> <p>1.1 Дос 8168- Агаарын навигацийн үйлчилгээний журмууд, Агаарын хөлгийн үйл ажиллагаа -Боть 1;</p> <p>1.2 Дос 8168- Нислэгийн журмууд Боть 2, Ил харааны болон Хэрэглэлийн нислэгийн журмуудыг зохиох;</p> <p>1.3 Дос 8697- Нислэгийн зургуудын гарын авлага;</p> <p>1.4 Дос 9365- Цаг уурын үйл ажиллагааны гарын авлага;</p> <p>1.5 Дос 9613- Үзүүлэлтэд тулгуурласан навигацийн гарын авлага Боть1;</p> <p>1.6 Дос 9613- Ухагдахуун болон хэрэгжүүлэлтийн заавар, Боть 2 RNAV болон RNP-г хэрэгжүүлэх;</p> <p>1.7 Дос 9881- Электрон газрын гадарга, Үндэс болон аэродромын газрын зургийн мэдээллийн зааврууд.</p> <p>2/ Чикагогийн конвенцийн Хавсралтууд:</p> <p>2.1 Хавсралт 4. Нислэгийн зураглал;</p> <p>2.2 Хавсралт 6. Агаарын хөлгийн үйл ажиллагаа;</p> <p>2.3 Хавсралт 11. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ;</p> <p>2.4 Хавсралт 14. Аэродром, Боть 1, 2;</p> <p>2.5 Хавсралт 15. Нислэгийн мэдээллийн үйлчилгээ.</p> <p>3/ Нислэгийн журмын тодорхой төрөлд тохиромжтой бөгөөд ИНЕГ-ын даргын зүгээс хүлээн зөвшөөрөгдсөн бусад заавар болон стандартууд.</p> <p>(б) Энэ зүйлийн (а)-д заасан зохиох үйл явц, стандарт, заавар болон нислэгийн өгөгдлийн чанарын шаардлагын хооронд зөрүү гарсан тохиолдолд ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн зохиох үйл явц, стандарт болон зааврыг ашиглана.</p> <p>(в) Нислэгийн журмыг зохиохдоо:</p> <p>1/ нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ эрхлэгчидтэй харилцан зөвшилцсөн байна;</p> <p>2/ Нислэгийн журам зохиохоор төлөвлөсөн бүс болон агаарын зайн бүсүүдийн дотор үйлчилдэг аливаа нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний журамд</p>	<p>-Amend.2-оор хүчингүй болсон</p>
--	--	-------------------------------------

	<p>нийцэж байна; 3/ дараах зүйлсийг харгалзан үзнэ: 3.1 агаарын хөлгийн үйл ажиллагааг хязгаарласан дүрэм болон бусад эрх зүйн баримт бичиг; 3.2 Нислэгийн журам зохиох агаарын зайн ангилал болон тэдгээрийн нэршлүүд, журам нөлөөлж болох зэргэлдээ агаарын зай; 3.3 төлөвлөсөн Нислэгийн журмын агаарын зайд зохиогдсон бусад Нислэгийн журамд үзүүлэх нөлөө.</p> <p>(г) Нислэгийн тоног төхөөрөмжийг ИНД-171-ийн дагуу гэрчилгээ эзэмшигч байгууллагаас гэрчилгээжүүлээгүй тохиолдолд уг тоног төхөөрөмжид тулгуурлан, эсхүл тэдгээрийг ашиглан Нислэгийн журам зохиохûā õïðèäëïï.</p>	
	<p>Хавсралт А. Нислэгийн журам гэрчилгээжүүлэх ажилтны мэргэшил болон туршлага Нислэгийн журам гэрчилгээжүүлэх ажилтан нь мэргэшил болон туршлагын хувьд дараах шаардлагыг хангасан байна: 1/ Сургалт – Нислэгийн журам зохиох ICAO-ийн PANS-OPS сургалт дамжаа, эсхүл ИНЕГ-ын даргаас хүлээн зөвшөөрсөн ижил түвшний сургалтад амжилттай хамрагдсан байх 2/ Нислэгийн журмыг ашиглах туршлага- Нислэгийн журмыг ашиглан хэрэглэлийн нислэгийн дүрэм болон ил харааны нислэгийн дүрмээр үйлдэх нислэгүүдэд нисэх багийн гишүүнээр оролцсон, эдгээр нислэгүүдийн үйл ажиллагааг хянаж байсан, нислэгийн хөдөлгөөний удирдлагад ажиллах зэргээр 10-аас доошгүй жил Нислэгийн журмыг ашигласан, эсхүл ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн түүнтэй тэнцэх дадлага туршлагатай байна. 3/ Нислэгийн журам зохиох туршлага- 2 жилээс доошгүй хугацаанд Нислэгийн журам зохиосон туршлагатай байна. Үүнд: 3.1 ИНЕГ-ын даргаар хүлээн зөвшөөрөгдсөн мэргэшил, ур чадвар бүхий журам зохиогчийн удирдлагад тухайн ажилтан зохиох болон гэрчилгээжүүлэхээр төлөвлөсөн төрлөөр 3-аас цөөнгүй Нислэгийн журам зохиосон; 3.2 Нислэгийн журмын шинэ төрлийг зохиох тохиолдолд ИНЕГ-ын даргаар хүлээн зөвшөөрөгдсөн ижил төрлийн</p>	<p>-Amend.2-оор хүчингүй болсон</p>

	Нислэгийн журмын төрлийг зохиосон болон гэрчилгээжүүлсэн.	
<p>173.201. Журам зохиох</p> <p>(a) <u>Хэрэглэлийн нислэгийн журмыг энэ Дүрмийн шаардлага болон дараах баримт бичигт заасан холбогдох журам зохиох үйл явц, стандарт, зааварчилгаа болон нисэхийн өгөгдлийн чанарын шаардлагын дагуу зохиодог байх ёстой:</u></p> <p>(1) <u>ICAO-гийн Баримт бичиг:</u></p> <p>(i) <u>Doc 8168, Procedures for Air Navigation Services - Aircraft Operations - Volume I Flight Procedures, and Volume II, Construction of Visual and Instrument Flight Procedures:</u></p> <p>(ii) <u>Doc 8697, Aeronautical Chart Manual:</u></p> <p>(iii) <u>Doc 9365, Manual of All-Weather Operations:</u></p> <p>(iv) <u>Doc 9613 Performance Based Navigation Manual - Volume I Concept and Implementation Guidance, and Volume II Implementing RNAV and RNP:</u></p> <p>(v) <u>Doc 9881, Guidelines for Electronic Terrain, Obstacle and Aerodrome Mapping Information:</u></p> <p>(2) <u>ICAO-гийн Хавсралт:</u></p> <p>(i) <u>Хавсралт 4, Нислэгийн зураг:</u></p> <p>(ii) <u>Хавсралт 6, Агаарын хөлгийн үйл ажиллагаа:</u></p> <p>(iii) <u>Хавсралт 11, Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ:</u></p> <p>(iv) <u>Хавсралт 14, Volumes I болон II Аэродром:</u></p> <p>(v) <u>Хавсралт 15, Нисэхийн мэдээллийн үйлчилгээ:</u></p> <p>(3) <u>тодорхой хэрэглэлийн нислэгийн журмын төрөлд хамааралтай болон Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад зааварчилгаа, эсхүл стандарт.</u></p> <p>(b) <u>Энэ зүйлийн (a)-ийн зорилгоор, хэрэв холбогдох журам зохиох үйл явц, стандарт, зааварчилгаа, эсхүл нисэхийн өгөгдлийн чанарын шаардлагуудын хооронд зөрчилдөх ялгаа байгаа бол ашиглах тухайн журам зохиох үйл явц, стандарт эсхүл зааварчилгаа нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц, эсхүл Даргын заасан байх ёстой.</u></p> <p>(c) <u>Хэрэглэлийн нислэгийн журмыг зохиохдоо дараах шаардлагыг хангасан байх ёстой:</u></p> <p>(1) <u>холбогдох бүх НХҮ-ний байгууллагатай хамтран зохицуулдаг байх;</u></p> <p>(2) <u>тухайн хэрэглэлийн нислэгийн журмыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бүс, эсхүл агаарын зайн бүсэд үзүүлдэг аливаа НХҮ болон холбогдох журамтай нийцдэг байх;</u></p> <p>(3) <u>дараах шаардлагыг тооцон үзсэн байх:</u></p>		-Amend.16-аар нэмэгдсэн

<ul style="list-style-type: none"> (i) <u>дуу намсгах журам;</u> (ii) <u>агаарын хөлгийн үйл ажиллагааг хязгаарласан аливаа хууль, эсхүл бусад эрх зүйн баримт бичиг;</u> (iii) <u>тухайн хэрэглэлийн нислэгийн журмыг хэрэгжүүлэх агаарын зай болон тухайн журам нөлөөлж болох зэргэлдээх агаарын зайн ангилал, тогтоосон зориулалт;</u> (iv) <u>тухайн агаарын зайд тогтоосон бусад хэрэглэлийн нислэгийн журамд санал болгосон тухайн хэрэглэлийн нислэгийн журмын үзүүлэх нөлөө.</u> (d) <u>Төлөвлөсөн хэрэглэлийн нислэгийн журмыг ашиглан тухайн аэродром, эсхүл хэлипортыг IFR нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж болохыг тухайн аэродром, эсхүл хэлипортын үйл ажиллагаа эрхлэгч бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд, хэрэглэлийн нислэгийн журмыг аэродром, эсхүл хэлипортод зориулан зохиохгүй.</u> (e) <u>Дараахаас бусад тохиолдолд, хэрэглэлийн нислэгийн журмыг газарт суурилсан нисэхийн байгууламж дээр, эсхүл түүнийг ашиглан зохиохгүй:</u> <ul style="list-style-type: none"> (1) <u>тухайн нисэхийн байгууламж нь ИНД-171-ийн дагуу олгосон АНТҮБ-ын гэрчилгээний эрхийн хүрээнд ажилладаг байх;</u> (2) <u>АНТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь тухайн нисэхийн байгууламжийг төлөвлөсөн хэрэглэлийн нислэгийн журамд ашиглаж болохыг бичгээр зөвшөөрсөн байх.</u> 		
<p>Е Бүлэг - Шилжилтийн зохицуулалт</p>		
<p><u>173.301. ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийн шилжилт</u></p> <ul style="list-style-type: none"> (a) <u>Энэ зүйл нь дараах этгээдэд хамаарна:</u> <ul style="list-style-type: none"> (1) <u>ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмшигч;</u> (2) <u>ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч.</u> (b) <u>Энэ зүйлд хамаарах байгууллага нь энэ зүйлийн (e)(2)-ын дагуу тогтоосон хэрэгжүүлэлтийн хугацаанаас өмнө дараах заалтыг мөрдөхгүй байж болно:</u> <ul style="list-style-type: none"> (1) <u>173.51(a)(2)(iii) хэрэв тухайн байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтны оронд дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтантай бол;</u> (2) <u>173.69 хэрэв тухайн байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх болон мөрдөхийн оронд, 173.303-ыг хангасан дотоод чанар</u> 		<p>- Amend.2-оор нэмэгдсэн</p>

баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн бол:

(3) 173.71(a)(1A)(i):

(4) 173.71(a)(3)(ii):

(5) 173.71(a)(4A).

(c) ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмшигч болон ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь гүйцэд бөглөсөн САА маягт болон хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг 2020 оны 2 сарын 1-нээс өмнө Даргад хүргүүлэх үүрэгтэй:

(d) Энэ зүйлийн (c)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлага хангасан байх ёстой:

(1) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн санал болгосон хугацааг багтаасан байх;

(2) тухайн байгууллага 173.69-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг дүрслэн харуулсан байх.

(e) Хэрэв хүлээн зөвшөөрөхүйц бол Дарга:

(1) тухайн байгууллагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батална;

(2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн хугацааг тогтооно.

(f) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу хугацааг тогтоохдоо Дарга дараах нөхцөлийг тооцох үүрэгтэй:

(1) тухайн байгууллагын хүчин чадал;

(2) тухайн байгууллагын төвөгшил;

(3) тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрсдэл;

(4) гэрчилгээг сунгах хугацаа;

(5) тухайн байгууллага, эсхүл ИНЕГ, эсхүл хоёуланд нь хамаарах эх үүсвэр, эсхүл хуваарийн нөлөө;

(6) хэрэгжүүлэлтийн хугацаа нь 2021 оны 2 сарын 1-нээс хойш байж болохгүй;

(g) Энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ сунгуулах хүсэлтэд хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг хавсаргахгүй байж болно.

(h) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-нд хүчингүй болно.

173.303. ХНЖУБ-ын гэрчилгээ эзэмшигчийн шилжилтийн дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо

- (a) Энэ Дүрмээр шаардсан журам нь дүрмийн шаардлага хангасан ба тухайн байгууллага түүнийг хэрэгжүүлж байгааг бататгах зорилгоор 173.301(b)(1)(ii)-т шаардсан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн байх ёстой.
- (b) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо нь дараах журмыг багтаасан байх ёстой:
 - (1) ИНД-12-ын дагуу аливаа хэрэг явдлыг мэдээлэх болон шинжлэн шалгах журмыг багтаасан аюулгүй байдлын соёл болон аюулгүй байдлын журмыг сайжруулах нэгдсэн аюулгүй байдлын бодлого;
 - (2) аюулгүй байдлын үзүүлэлтийг тогтоох болон хянах журам;
 - (3) байгууллагын тогтолцоо болон үйл явцад оршиж байгаа, эсхүл хүндрэл үүсэж болох асуудлыг таньж тогтоох журам;
 - (4) хэрэглэлийн нислэгийн журмын үнэн зөв байдалд нөлөөлж болох, байгууллага доторх эрсдэлийг хянах болон бууруулах журам;
 - (5) илрүүлсэн хүндрэлтэй асуудлыг шинжлэн шалгаж, дүн шинжилгээ хийсэн ба хүндрэлтэй асуудлын шалтгааныг арилгасан болохыг бататгах залруулах арга хэмжээний журам;
 - (6) илрүүлсэн хүндрэлтэй асуудлын боломжит шалтгааныг арилгасан болохыг бататгах урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам;
 - (7) хүсэлт гаргагчийн байгууллагын Ерөнхий заавар, аюулгүй байдлын бодлого болон журамд нийцүүлэх зорилгоор аудит хийх дотоод аудитын хөтөлбөр;
 - (8) энэ Дүрмийн шаардлагыг хангасан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны байнгын тохиромжтой болон үр дүнтэй байдлыг бататгах, хэрэв тохирч байгаа бол, статистикийн дүн шинжилгээ ашиглахыг багтаасан удирдлагын дүгнэлт хийх журам;
 - (9) дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны үйл ажиллагааг баримтжуулах болон эрсдэл, тэдгээрийг хэрхэн зохицуулах ((b)(1) - (b)(8)-д шаардсан журмыг багтаасан) байгууллагын ноцтой аюулыг бүртгэх болон тэдгээрийг хянахтай холбоотой мэдээллээр хангах

-Amend.2-оор нэмэгдсэн

- дотоод чанар баталгаажуулалтын заавар.
- (c) Дотоод чанар баталгаажуулалтын журам нь аюулгүй байдлын бодлогыг байгууллагын бүх түвшинд ойлгож, хэрэгжүүлж, мөрдөж байгааг бататгах аргачлалыг багтаасан байх ёстой.
- (d) Энэ зүйлийн (b)(5)-д шаардсан залруулах арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг хэрхэн хийхийг заасан байх ёстой:
- (1) оршиж байгаа хүндрэлтэй асуудлыг залруулах;
 - (2) тухайн хүндрэлтэй асуудал нь аливаа хэрэглэлийн нислэгийн журмын үнэн зөв байдалд нөлөөлсөн, эсхүл нөлөөлж болзошгүй эсэхийг хэрхэн тодорхойлох;
 - (3) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах залруулах арга хэмжээг эргэн хянах;
 - (4) залруулах арга хэмжээний үр дүнд үндэслэн энэ Дүрмээр шаардсан журамд нэмэлт өөрчлөлт оруулах;
 - (5) авсан залруулах арга хэмжээний үр дүнг удирдлага дүгнэх.
- (e) Энэ зүйлийн (b)(6)-д шаардсан урьдчилан сэргийлэх арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг хэрхэн хийхийг заасан байх ёстой:
- (1) хүндрэл үүсгэж болох асуудлыг залруулах;
 - (2) тогтоосон хүндрэл үүсгэж болох асуудлын шалтгаан өөр ямар нөлөөтэй байж болохыг хэрхэн тодорхойлох;
 - (3) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах урьдчилан сэргийлэх арга хэмжээг эргэн хянах;
 - (4) урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд үндэслэн энэ Дүрмээр шаардсан журамд нэмэлт өөрчлөлт оруулах;
 - (5) авсан урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг удирдлага дүгнэх.
- (f) Энэ зүйлийн (b)(7)-д шаардсан дотоод аудитын хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:
- (1) аудит хийх үйл ажиллагааны шинж чанарыг тооцож аудит хийх байрлал болон давтамжийг тогтоодог байх;
 - (2) аудитыг тухайн үйл ажиллагаанд шууд хариуцлага хүлээдэггүй, сургалтад хамрагдсан аудитын ажилтан гүйцэтгэдэг болохыг бататгадаг байх;
 - (3) аудитын үр дүнг, аудит хийгдсэн ажиллагааг хариуцсан ажилтан болон дотоод аудит хариуцсан удирдах ажилтанд мэдээлдэг болохыг бататгадаг байх;
 - (4) сүүлчийн аудитаас хойш, аудит хийгдсэн тухайн

<p><u>ажиллагааг хариуцсан ажилтны авсан урьдчилан сэргийлэх, эсхүл залруулах арга хэмжээний үр дүнг үнэлж дүгнэдэгхийдэг байх;</u></p> <p>(5) <u>хэрэв аудитаар хүндрэлтэй асуудал илэрсэн бол аудит хийгдсэн ажиллагааг хариуцсан ажилтнаас урьдчилан сэргийлэх, эсхүл залруулах арга хэмжээ авахыг шаарддаг байх;</u></p> <p>(6) <u>авсан урьдчилан сэргийлэх, эсхүл залруулах арга хэмжээний үр дүнд дүгнэлт хийх зорилгоор эргэн хянах аудит хийдэг болохыг бататгадаг байх.</u></p> <p>(g) <u>Энэ зүйлийн (b)(8)-д шаардсан удирдлагын дүгнэлт хийх журам нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:</u></p> <p>(1) <u>тухайн тогтолцооны байнгын үр дүнтэй байх хэрэгцээ шаардлагыг үндэслэн дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоонд удирдлагын дүгнэлт хийх давтамжийг тогтоодог байх;</u></p> <p>(2) <u>удирдлагын дүгнэлт хийх хариуцлага хүлээсэн удирдах ажилтныг тодорхойлдог байх;</u></p> <p>(3) <u>тухайн дүгнэлтийн үр дүнг дүгнэж, бүртгэл хөтөлдөг байхыг шаарддаг байх.</u></p> <p>(h) <u>Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан нь тухайн байгууллагын хариуцдаг аливаа хэрэглэлийн нислэгийн журмын үнэн зөв байдалд нөлөөлөх асуудлаар Гүйцэтгэх захиралтай шүүд харьцдаг байх үүрэгтэй.</u></p> <p>(i) <u>Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-нд хүчингүй болно.</u></p>		
<p><u>Хавсралт А - Удирдах ажилтнуудын мэргэшил болон туршлага</u></p> <p><u>Энэ Хавсралт нь 173.51(a)(2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын мэргэшил болон дадлага туршлагын шаардлагыг тогтооно.</u></p> <p><u>А.1. Хэрэглэлийн нислэгийн журмыг гэрчилгээжүүлэх удирдах ажилтан</u></p> <p>(a) <u>Сургалт - хэрэглэлийн нислэгийн журам зохиох ICAO PANS-OPS-ийн сургалтын курс, эсхүл Даргын хүлээн зөвшөөрсөн дүйцэх сургалтын курст амжилттай хамрагдсан байх.</u></p> <p>(b) <u>Хэрэглэлийн нислэгийн журмыг хэрэглэх туршлага - IFR нислэгийн үйл ажиллагааны</u></p>		<p>- Amend.2-оор нэмэгдсэн</p>

хяналтад IFR нислэгт нисэх багийн гишүүнээр нислэгийн хөдөлгөөний удирдлагын хяналтад хуримтлуулсан, 10 доошгүй жил хэрэглэлийн нислэгийн журмыг хэрэглэсэн туршлага, эсхүл Даргын хүлээн зөвшөөрсөн бусад дүйцэх туршлагатай байх.

(с) **Хэрэглэлийн нислэгийн журам зохиох туршлага** - дараах шаардлагыг багтаасан, хэрэглэлийн нислэгийн журам зохиох 2-оос доошгүй жилийн туршлагатай байх:

- (1) Даргын хүлээн зөвшөөрсөн мэргэшилтэй журам зохиогчийн удирдлагад ажилтанд гэрчилгээжүүлэх эрх олгох тухайн төрлийн 3-аас доошгүй хэрэглэлийн нислэгийн журмыг зохиосон байх; эсхүл
- (2) шинэ хэрэглэлийн нислэгийн журмын төрлийн хувьд, ижил хэрэглэлийн нислэгийн журмын төрлийг зохиох, эсхүл гэрчилгээжүүлэх Даргын хүлээн зөвшөөрсөн туршлагатай байх.

A.2. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан

Энэ дүрмийн 173.51(a)(2)(iii)-г шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнууд нь гэрчилгээ эзэмшигчийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болон үйл ажиллагаатай холбоотой үр чадвар, туршлагаа харуулах чадвартай байх үүрэгтэй.